

Хамтран ажиллах тухай удирдамж



**БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ТӨВ**

УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар
хороо, Алтангэрэлийн гудамж 5, Утас: 7577 8080,
И-мэйл: info@edu.mn, Вэбсайт: www.edu.mn

2022. 04. 14 № 1/63
танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР,
АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ ГАЗРЫН ДАРГА ТАНАА**

Хамтран ажиллах тухай

Боловсрол, шинжлэх ухааны Сайдын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/04 дугаар "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай" тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан удирдамжийн "Ахлах ангийн сонгон суралцах хичээлийг хэрэгжүүлэх, цахим сургууль, сургалтыг зохион байгуулах үйл ажиллагааг тодорхойлж, эрх зүйн баримт бичиг боловсруулах" ажлын хүрээнд дараах хоёр төрлийн судалгаа авах ажлыг зохион байгуулж байна. Үүнд:

1. 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангид суралцах суралцагчдын сонгон судлах хичээлийн сонголт;
2. Сонгон судлах 15 хөтөлбөрийг цахим хэлбэрээр зохион байгуулах багшлах хүний нөөцийн бэлэн байдал;

Судалгааг боловсролын салбарын мэдээллийн системээр дамжуулан нэгтгэх бөгөөд 2022 оны 04 дүгээр сарын 29-ны 17:00 цагт хаагдана.

Дээрх судалгааны асуумжийг бүрэн гүйцэд бөглөж ирүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган, хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ үү.

Нийслэлийн боловсролын газар болон аймгийн боловсрол, шинжлэх ухааны газрын статистикийн мэргэжилтнүүдэд асуулгын явцыг хянах боломжоор хангасан болно. Судалгаа, асуумж бөглөх заавар, аргачлалыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай.

**ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**



Ц.ТОДГЭРЭЛ

